

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭРХ ЗҮЙН
АЖЛЫН ТАЙЛАН

2021.12.13

Тус хэлтэс нь хууль зүйн салбарын бодлого, зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт зорилго, арга хэмжээ, "Орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих жил"-д зориулан иргэдийн оролцоог дэмжиж соён гэгээрүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, үйлчилгээг иргэд, олон нийт, албан хаагч аж ахуйн нэгж, байгууллагад хүртээмжтэй хэлбэрээр хүргэж, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангахын зэрэгцээ хэлтэс, агентлагийн удирдлагууд, сумдын Засаг дарга, сумдад бэлтгэгдсэн "Эрх зүйн хөтөч"-үүд, сумдын орон тооны бус "Эрх зүйн хөтөч" багийн ахлагч буюу сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон бусад холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг хууль тогтоомж хэрэгжүүлэх, сурталчлах ажилд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, тэднээс гаргасан санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн хариу өгөх, цаашид хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын Тамгын газрын болон хэлтсийн хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2021 онд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэлт,
бүртгэн цэгцлэх ажлын гүйцэтгэл, иргэд, аж ахуйн нэгжид
цахим болон гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн талаар

Тайлант хугацаанд эрх зүйн мэдээллийн өөрчлөлт хөдөлгөөний бүртгэлийн нэгдсэн санд нийт 693 эрх зүйн актыг бүртгэсэн ба үүнээс шинээр 35, нэмэлт, өөрчлөлт орсон 535 хууль, Засгийн газрын тогтоол 41, УИХ-ын тогтоол 59, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 9, Ерөнхийлөгчийн зарлиг 13-ийг тус тус бүртгэн санг баяжуулж, өдөр тутмын болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хүчингүй болгосон, зүйл заалт хассан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт давхардсан тоогоор 8 хууль, тогтоомж, хүчингүй болсон хасагдсан 109 зүйл заалтыг тухай бүр эрх зүйн ангилал хийж, тамга тэмдэг дарж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цахим болон гар сангаас лавлагаа мэдээллийг 135 иргэн, албан тушаалтанд үзүүлж үйлчилгээг хүргэлээ.

Аймгийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг
хянаж санал дүгнэлт өгөх, тухайн жилд гаргасан захиргааны
хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг зохих журмын дагуу
хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны
төв байгууллагад хянуулж, бүртгүүлсэн талаар

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 420 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, төслийн шатанд захирамж боловсруулсан этгээдээр санал авах хуудас болон хяналтын дагалдах хуудсыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон хэлтсийн дарга нараар хянуулж санал авах ажлыг зохион байгуулж байна. Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 428 захирамжийг аймгийн www.dundgovi.gov.mn вэб сайтын эрх зүйн актууд цэсний Засаг даргын захирамжууд хэсэгт байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, зарим шийдвэрийг байгууллага, иргэдэд хуулбар хувиар хүргүүлэн ажиллалаа.

Луус, Өлзийт, Дэлгэрцогт сумдын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын батлан гаргасан "Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай" 3 эрх зүйн актыг улсын нэгдсэн санд бүртгүүлээ.

Сумын Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж
буй эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг
арилгуулах талаар авсан арга хэмжээ

Сумдын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хянах хуваарийг батлан хүргүүлж, уг хуваарийн дагуу хянах, зөвлөмж хүргүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллалаа.

2021 онд сумдын Засаг дарга нарын батлан гаргасан 1298 эрх зүйн акт, сумдын төрийн байгууллагуудын дарга нараас батлан гаргасан 798 эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж хүргүүлэхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нараас батлан гаргасан 709 тушаалыг хуваарийн дагуу хянаж, нийт 682 эрх зүйн актад гаргасан зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.


Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чанар, үр дүн, шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авсан талаар

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд халдварт цар тахалтай холбогдуулан сургалт, сурталчилгааг цахимаар болон танхимын хэлбэрээр зохион байгуулан, эрх зүйн сургалтыг 9 удаа 779 хүнд, сурталчилгааг “Дундговь Эрх зүйн хөтөч” пэйж хуудсаар аймаг, сумын эрх зүйн хөтөчүүд 233 нийтлэлийг байршуулан иргэд, олон нийтэд хүргэж, хууль, эрх зүйн туслалцаа хүссэн 345 хүнд Хууль туслалцааны төвийн өмгөөлөгчийн хамт үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгууллаа.




Эрх зүйн албан ба албан бус сургалтыг сум, байгууллагуудын удирдлагууд, Эрх зүйн хөтөч нараар дамжуулан иргэн бүрт эрх зүйн боловсрол олгох 3 сарын аян зохион байгуулах, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд хамтран ажиллаж семинар, сургалтыг цахим хэлбэрээр хүргэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:


➤ Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс нээсэн “Эрх зүйн хөтөч нэгдсэн групп”, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс нээсэн “Дундговь Эрх зүйн хөтөч пэйж хуудас”, “Дундговь Эрх зүйн хөтөч” чат зэрэг цахим хуудсуудаар Эрх зүйн хөтөчүүдийг цахим хэлбэрээр арга зүйн удирдлага, мэдээллээр ханган, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа.



➤ Эрх зүйн хөтчийн нэгдсэн группт аймаг, сумдын Эрх зүйн хөтөчүүд нэгдэж тус группт тавигдсан хууль, эрх зүйн сурталчилгааны мэдээ, мэдээлэл, 1800-1202 подкастын цуврал дугааруудыг тухай бүрт нь Эрх зүйн хөтөчүүд шэйрлэж олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахаас гадна өөрсдийн бэлтгэсэн “Гэр бүл гэж юу вэ”,



“Хүүхдийн тэтгэлэгийн ажиллагаа харандааны адал явдал” 2 шторкийг группээр, Хууль зүйн ирүүлсэн Мэдээллийн ил тухай, Ан амьтны тухай, Хот суурин газрыг дахин эрхлэлтийг дэмжих, иргэдийн тухай, Хөгжлийн



Хүүхэд хамгаалах тухай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Малын хулгайтай тэмцэх, Ойн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай зэрэг 14 хууль тогтоомжоор бэлтгэсэн шторкийг цувралаар олон нийтэд хүргэлээ.

“Дундговь Эрх зүйн хөтөч” үндэсний хүрээлэнгээс бэлтгэн тод байдал, Ахмад настны Байгаль орчны, Эрүүл мэндийн, Хөгжүүлэх, Хөдөлмөр Хөгжлийн бэрхшээлтэй бодлого төлөвлөлтийн тухай,

➤ “Бүх нийтийн эрх хэрэгжүүлэх арга оны аймгийн төлөвлөгөө боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний 2021 оны ыг төлөвлөгөөндөө зүйн зөвлөгөө, зөвлөмжийг газрын дарга нарт ЗДТГ-ын дарга буюу “Эрх ахлагч нарт “Бүх нийтийн үндэсний хөтөлбөр”-ийг төлөвлөлтийг оновчтой

зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэмжээний II шатны буюу 2020-2023 болон улсын “Бүх нийтийн эрх зүйн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу сумын ЗДТГ-тодотгол хийж хэрэгжүүлэх арга сумдын Засаг даргын Тамгын хүргүүлэн, сумдын Засаг дарга, зүйн хөтөч” орон тооны бус багийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хэрэгжүүлэн ажиллах,



зохион байгуулах, эрх зүйн албан бус цахим сургалтыг үр дүнтэй зохион байгуулах, иргэд, олон нийтэд цахим хэлбэрээр сургалт, сурталчилгааг хүргэх, эрх зүйн хөтөчүүдийг арга зүйн удирдлагаар хангаж, тэднийг дэмжин ажиллах талаар семинар, сургалтыг танхимаар зохион байгууллаа. Энэ үеэр аймагт ажиллаж буй өмгөөлөгчид болон сумдын “Эрх зүйн хөтөч нарын дэлгэрэнгүй танилцуулгыг 300 ш, иргэдэд нэн шаардлагатай хууль тогтоомжоор 300 ш гарын авлагыг тус тус бэлтгэн сумдад нийт 600 ширхэгийг иргэдэд хүргүүлэхээр түгээсэн.

➤ Эрх зүйн хөтөч орон тооны бус баг үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор газрын албан хаагчдаас 2021 онд судлан актын хөтөлбөрийн жагсаалтыг улирал зохион байгуулуулахаар жагсаалтыг тавин, цахим хэлбэрээр сурталчилж

➤ “Орон нутгийн хөгжилд иргэдийн зориулан “Бүх нийтийн эрх зүйн цахим хэлбэрээр дээшлүүлэх нь” 3 сарын аяныг 04 өдрөөс эхлэн аймаг, сумын хэмжээнд зохион иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, болон цахим бус байдлаар нээлттэй, энгийн хэлбэрээр бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилт тавин, хууль, эрх зүйн сурталчилгаануудыг цувралаар хүргэх 11 төрлийн зохион байгуулан, сумдын онцлох ажлуудыг нэгтгэн хэрэгжүүлж ажилласан.

➤ Халдварт цар тахалтай холбогдуулан сумдын “Эрх зүйн хөтөч”-үүдийг чадавхжуулах эрх зүйн албан бус аймгийн Шүүх, Шүүхийн Цагдаагийн газар, Улсын үндэсний комиссын аймаг даатгалын хэлтэс, Эрүүл Хөдөлмөр халамжийн харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Хууль туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, аймгийн Насан туршийн боловсролын төв зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран 60 эрх зүйн хөтөчүүдэд нэг өдрийн эрх зүйн сургалтыг амжилттай зохион байгуулж, “Эрх зүйн хөтөч”-үүд бүрэн хамрагдаж цахим сургалтыг үр дүнтэй боллоо гэж үнэлсэн.

Сумдын “Эрх зүйн хөтөч”-үүд 3 дах жилдээ ажиллан, тэдний зохион байгуулсан үйл ажиллагааг “Эрх зүйн хөтөч”-ийн



ЭРДЭНЗДАЛАЙ СУМАНД БЭЛТГЭГДСЭН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧҮД

№	Огноо	Нэр	Хүний нэгж	Утасны дугаар
1	Бүтэц	Бүтэц	Хүтэц арх хүйс СӨГ	9810821
2	Материал	Бүтэц	ЗДТГ-ын дарга	9810878
3	Бүтэц	Бүтэц	Засаг дарга	9810895
4	Бүтэц	Бүтэц	Засаг дарга	9810821

АЙМАГ ДАХЬ ӨМГӨӨЛӨГЧ НАРЫН МЭДЭЭ

№	Огноо	Нэр	Хүний нэгж	Утасны дугаар
1	Бүтэц	Бүтэц	Хүтэц арх хүйс СӨГ	9810821
2	Материал	Бүтэц	ЗДТГ-ын дарга	9810878
3	Бүтэц	Бүтэц	Засаг дарга	9810895
4	Бүтэц	Бүтэц	Засаг дарга	9810821



болон “Эрх зүйн хөтөч” нарын сумын Засаг даргын Тамгын сурталчлах, хууль, эрх зүйн бүр 4-5 хууль тогтоомжоор боловсруулан хүргүүлж, хяналт хамтран ажиллалаа.

оролцоог дэмжих жил”-д боловсролыг дүгээр 14-ний байгуулан мэдлэгийг цахим хялбарчилсан тасралтгүй

үйл ажиллагааг сум бүрт хүргэн

зүйн



ажлыг дүгнэх батлагдсан шалгуур үзүүлэлтээр хагас, бүтэн жилээр сумын ЗДТГ-ын дарга нар үнэлж дүгнэх ажлыг хийж байна.


➤ "Хуульчийн ПРО-БОНО өдөр-2021" арга хэмжээний хүрээнд 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч болон аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгчидтэй хамтран утсаар, цахимаар иргэдэд Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, үйлчилгээг 51 иргэнд үзүүлж, сурталчилгаат үйл ажиллагаануудыг зохион байгуулав.

➤ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос Цар тахлын үеийн шийдвэр гаргалт ба хүний эрх цахим хэлэлцүүлэгийг аймгийн удирдах албан тушаалтнуудад зохион байгуулж, оролцсон албан тушаалтнууд тулгарч буй зарим асуудлыг тодруулан нэг ойлголттой болж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

➤ Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх бэлтгэсэн Надад итгэ, Гэнэн Цогоо, Ариун Дуудлага, Хүү, Чимээгүй хөрш зэрэг 6 хэмжээний киног www.dundgovi.gov.mn аймгийн Засаг даргын Тамгын газар, пэйж хуудас, сум, байгууллагуудын пэйж хуудас, аймгийн төвд байрлаж буй улирлаар сурталчлан таниуллаа.

➤ "Дундговь Эрх зүйн хөтөч" пэйж Эрх зүйн хөтөчүүдийг IV улиралд 7, 7 хоногоор иргэд, олон нийтэд зохион байгуулах цахим сурталчилгааны хуваар гарган ажиллуулсны үр дүнд 233 нийтлэлийг нийтэлж аймаг, сумын Эрх зүйн хөтөч, Насан туршийн боловсрол пэйж хуудсуудад байршуулан сурталчиллаа.

➤ "Гэмт хэргээс урьдчилан бүрт" нээлттэй өдөрлөгт хууль байгууллагуудтай хамтран Хулд, иргэд, албан хаагчид, ЕБС-ийн нийт шалтгаан нөхцөл" сэдвээр эрх зүйн байгуулан, нийтийн албан ашиг сонирхлыг хувийн ашиг ажиллах зөвлөгөө зөвлөмжийг өгч, ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.



бэлтгэн ирүүлсэн зорилготой эрхэм нандин, ширхэг богино вэбсайт, "Дундговь "Эрх зүйн хөтөч" вэбсайт болон ЛЕД дэлгэцээр

хуудсаар сумдын

сэргийлэх ажлыг "Сум хяналтын Луус, Дэлгэрцогт сумдын 300 хүнд "Авлига, авлигын сургалтыг зохион тушаалтнуудад нийтийн сонирхлоос өмнө тавьж Эрх зүйн хөтөчүүдийн үйл



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйл буюу аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд 2021 онд 145.0 сая төгрөг батлуулж, хууль сахиулах байгууллагуудын саналд үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөг тус зөвлөлийн нэгдүгээр хурлаар хэлэлцэн, 3 бүлэг 44 заалттайгаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас улсын чанартай зам дагуух 3 суманд согтуурал хэмжих багажаар хангаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангах ажилд 450.000 төгрөгний үнэ бүхий микрофон олгосон.

Хүүхдээс мэдүүлэг авах өрөөний зураг төслийг стандартын дагуу гаргаж аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хандан 9.024.700 төгрөгийг шийдвэрлүүлэн засвар үйлчилгээ, тохижилт хийсэн.

Аймгийн хэмжээний гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтын талаарх мэдээллийг нэгдсэн сангаас сар бүрээр гарган, нөхцөл байдалд дүгнэлт судалгаа хийж, аймаг, сумдын Засаг дарга нар, ГХУСАЗЗөвлөлүүдэд нийт 56 удаа танилцуулга хүргүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгуулсан.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг “Сум бүрт” нээлттэй өдөрлөгөөр Дэлгэрцогт, Луус, Хулд сумдад эрх зүйн сургалт сурталчилгаа зохион байгуулж 311 хүнийг хамрууллаа.

Мөн сумдын цагдаагийн хэсгийн алба хаагчдын үйл ажиллагааг дэмжиж нийт 20.1 сая төгрөгийн автомашин, компьютер, техник хэрэгслийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллалаа.

“Хайртай бүхнээ хамгаалъя” арга хэмжээний хүрээнд иргэд малчдыг мотоциклын ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүмүүн бид нэг л амьтай” 8 минутын зохиомжийг бэлтгэн түгээж цахим хаягт байршуулж 1.005.470 иргэнд хүргэсэн. Аймгийн нутаг дэвсгэрт зам тээврийн гэмт хэрэг, осол ихээр бүртгэгддэг эрсдэлтэй 5 цэг /хар цэг/-ийн судалгааг гаргаж, нарны зайгаар ажилладаг мигалка суурилуулан, 4х6 м хэмжээтэй “Ирээдүйгээ хамгаалъя”, “Хурдаа хас” самбарыг байршуулан Зөрчлийн хуулийн холбогдох заалтыг тусгасан сэрэмжүүлэг хүргэсэн. Улаанбаатар-Мандалговь чиглэлийн А0201, Мандалговь-Даланзадгад чиглэлийн А0202 магистрал замыг эргүүлийн хяналтад авч, цагийн менежментийг дагуу хуваарийг батлуулан 5 цэгт 24 цагийн байнгын хяналтад давхардсан тоогоор 260 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн. Авто тээврийн төв, Цагдаагийн газар хамтарч дээрх зам маршрут дээр хяналт шалгалтыг зохион байгуулсан ба АОК-с 1.183.840 төгрөгийг шийдвэрлэсэн. Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтарсан хяналт шалгалтын ажлын хэсгийн төлөөлөл уулзалт хийж хяналт шалгалтын ажлын явцын талаар ЗГХЭГ-ийн дэд дарга У.Бямбасүрэнд замын нөхцөл байдлыг танилцуулан Засгийн газарт танилцуулан арга хэмжээ авч ажиллах талаар саналыг хүргүүлсэн.

“Эх орон газар шороогоо хамгаалъя” 5 минутын видео зохиомжийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2. /Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох/, 24.5. /Хууль бусаар ан ангнах/, 24.6. /Хууль бусаар мод бэлтгэх/ дахь хэсгээр видео контент бэлтгэж цахим орчинд сурталчилсан.

“Дундговийн амьдрал” сонинд 1, урсдаг самбарт 4, Аюулаас сэргийлэх FM-107.5-аар 2 удаа мэдээлэл хийж, орон нутгийн олон дагагчтай зарын группүүдээр сурталчилсан.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэдэд сэтгэл зүйн тусламж, зөвлөгөө үзүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагад ирүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагатай хамтран нэгдсэн арга хэмжээ 1, хэсэгчилсэн арга хэмжээ 8, аян 1, уралдаан 1, сургалт, мэдээлэл, яриа таниулга 45, өдөрлөг 1 тус тус зохион байгуулан нийт 2015 иргэдийг хамруулж, 30 төрлийн зурагт хуудас, 31 төрлийн санамж сэрэмжлүүлгийг 5100 иргэнд тарааж, цахим орчинд 65 мэдээлэл, сэрэмжлүүлэг мэдээ /видео шторк/ 3 төрлийг байршуулан нийт 22.6 мянган иргэнд хүргэсэн. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон 49 иргэнд сэтгэл зүйн тусламж үзүүлэн 7 хүнийг хууль зүйн үйлчилгээнд, насанд хүрээгүй 3 хүнийг эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилсан.

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газартай хамтарч “Хамтарсан багаараа хамгаалъя” аяныг зохион байгуулан аяны хүрээнд ахуйн хүрээнд архиан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, үйлдэж болзошгүй 15 айл өрхөөр орж урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, 3 төрлийн санамж сэрэмжлүүлэг тараасан ба гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт хувийн хэрэг нээн хариуцсан багийн хэсгийн байцаагч нар биечилсэн хяналт тавин ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Үе тэнгийнхний дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх”, “Архи, тамхины хор нөлөө”, “Цахим орчны зохистой хэрэглээ” зэрэг сэдвээр МСҮТ-ийн 64 оюутан, ерөнхий боловсролын сургуулийн 457 сурагчдад сургалт мэдээлэл хийсэн.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус аймгийн Дэлгэрцогт, Дэрэн сумын нутаг дэвсгэрт малчдын бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, малчдын бүлэг, цагдаагийн байгууллагын хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулан малчдын 2 бүлэг, 30 өрхийн малчид оролцож Цагдаагийн газраас малын хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх малчид, цагдаагийн байгууллага, нутгийн зархиргааны байгууллагын хамтын уялдаа холбоог сайжруулах талаар санал солилцсон. Сумдын мал эмнэлгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч зэрэг 25 албан тушаалтныг хамруулан “Мал эмнэлгийн гарал үүсэл, ариун цэврийн гэрчилгээнд хяналт тавихад

анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Мал бүхий иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 580 ширхэг санамж сэрэмжлүүлэг бэлтгэн, хүргэсэн.

Эдгээр зохион байгуулсан ажлын үр дүнд аймгийн хэмжээнд 2021 оны 11 сарын байдлаар гэмт хэргийн илрүүлэлт 7.6 хувь, хулгайлах гэмт хэрэг 18.8 хувь үүнээс иргэдийн өмчийн хулгай 12.7 хувь, автотээврийн хулгай 60 хувь, мал хулгайлах гэмт хэрэг 26.3 хувь, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 16.6 хувь, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 30 хувь, нийт зөрчил 8.9 хувь, эрүүлжүүлэгдсэн хүн 49.04 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлтэй гарав.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр

Аймгийн ГХУСАЗСЗ, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудтай хамтран “АРХИГҮЙ АМЬДРАЛЫГ ЦОГЦЛООЁ” аяныг зохион байгуулж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг “Говийн хийморь” АА бүлгэмтэй хамтран ажиллаж давхардсан тоогоор 482 хүнд эрхэмлэвэл зохих эрхэм дадал, эрүүл амьдралын зөв дадал хэвшил төлөвшүүлэх зөвлөмж, мэдээллийг өгсөн. Тус бүлгэмийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор АА бүлгэмийн гишүүдийн уулзалтыг 1 удаа зохион байгуулж 80 гаруй хүн хамрагдаж сум бүртээ хийж хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцон хэлэлцэж, архи хэтрүүлэн хэрэглэгч 13 иргэн өөрийн болон гэр бүлийн хүсэлтээр АА бүлгэмд орж архинаас татгалзан эрүүл амьдралыг сонгосон байна.

Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг зорилтот бүлгийн 30 иргэнийг хамруулсан “Амьдрал сайхан” соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж дээрх иргэдийг Нэгдсэн эмнэлэгийн дүрс оношлогоо, сүрьеэ, сэтгэц, дотрын эмчид үзүүлэн 3 төрлийн шинжилгээнд хамруулж, архинд донтох өвчтэй 3 иргэний дүгнэлтийг гаргуулан архины албадан эмчилгээнд хамруулсан.

Арга хэмжээний үеэр Хувь хүний сургагч багш М.Санжаасүрэн “Өөрийгөө танин мэдэхүй”, “Би хэн бэ”, сэдэвт сургалтыг дасгал, “Говийн хийморь” АА бүлгэмийн гишүүн П.Бөхсайхан “Архинаас ангид байх нь” яриа таниулга хийж АА бүлгэмд нэгдэхийг уриалсан бөгөөд цугласан зорилтод бүлгийн иргэдээс 5 иргэн АА бүлгэмийн уулзалтад очихоо илэрхийлж 2 иргэн бүлгэмийн гишүүн болж архинаас татгалзан 7 хоног бүрийн уулзалтанд хамрагдаж байна.

Говийн хийморь АА бүлгэмтэй хамтран говийн бүсийн аймгуудын АА бүлгийн хамтарсан сургалт, зөвлөгөөнийг 2021 оны 12 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд зохион байгуулсан ба нийт 254 иргэн хамрагдсан.

Нийтээр тэмдэглэх баяр амралтын өдрүүд, шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоосонтой холбогдуулан аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах аж ахуй нэгжүүдэд цагийн хязгаар тогтоох, архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглох зохион байгуулалтын зарим арга хэмжээг авах талаар аймгийн Засаг даргаас 29 захирамж гаргуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар гар дээрээс архи согтууруулах ундаа худалдан борлуулсан 17 иргэний зөрчлийг илрүүлж 85 шил архи, согтууруулах ундаа хурааж 850.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

Эхний 11 сарын байдлаар эрүүлжүүлэгдсэн хүн 212-оор буюу 49.4 хувиар буурсан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, архивын тасгаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, архивын сан хөмрөгийн хадгалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын талаар

Тус аймгийн архиваас 2021 онд нөхөн бүрдүүлэлт хийх 15 хөмрөгийн үүсгэгчийн 1190 хадгаламжийн нэгжийг төрийн архивт хүлээн авч архивт баримт хүлээн авсан бүртгэл, актыг зааврын дагуу хөтлөж архивын сан хөмрөгөөр ангилан төрөлжүүлж хөмрөгт байрлуулсан.

Шинээр ашиглалтанд оруулсан 16 барилгын засвар, өргөтгөлийн үйл ажиллагаанд улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, 27 зураг төсөл техник технологийн цаасан болон тусгай төрлийн баримтаар архивт нөхөн бүрдүүлэлт хийж, 360 хадгаламжийн нэгжийг зохих журмын дагуу хүлээн авч акт, жагсаалтыг үйлдэж байрлуулав.

Архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг 4 удаа хуралдуулж архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагын жагсаалт, хуваарь болон сум, байгууллагын байнга хадгалах баримтын данс, бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, хадгалах хугацаа дууссан баримтын устгах хэргийн акт зэрэг нийт 13 сум, байгууллагуудын бүртгэл жагсаалтыг хянан хэлэлцэж хариуг холбогдох сум, байгууллагад хүргүүлэв.

Засгийн газрын тогтоолын дагуу Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан иргэд, байгууллагын өргөдөл, хүсэлтийг цахимаар хүлээн авах ажлыг зохион байгуулж, <https://e-archives.gov.mn-ээр> тус онд байгууллага, иргэдийн нийт 18 хүсэлтийг хүлээн авч холбогдох лавлагааг тоон гарын үсгээр гаргаж хүргүүлсэн.

Баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 250 ширхэг хайрцаг захиалан авч 30 хөмрөгийн 34 дансны 2496 хадгаламжийн нэгжийг хамгаалалтын хайрцагт хийж, заагуурыг шинэчлэв.


Төрийн архивын баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд 21 хөмрөгийн 25 дансны 398 хадгаламжийн нэгжийн 42934 хуудас баримтыг цахим санд оруулаад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль болсонтой холбогдуулан 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар битүүмжилсэн 71 ширхэг саналын хуудсыг хүлээж аваад байна.

Үндэсний архивын газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг ажиллаж архивын баримтыг иргэд, байгууллагын нийгэм эрх зүйн олгох ажлыг хийж гүйцэтгэснээр тус хүсэлтийг хүлээн авч 341 иргэнд хувь хуулбар гарган өгч, нийт 1300 гаргаж үйлчилсэн. Эдгээр лавлагаанд гаруй хадгаламжийн нэгжийг мэдээлэл лавлагааны ажилд ашиглууллаа.

Уншлагын танхимаар үйлчлүүлсэн 11 иргэнд 170 хадгаламжийн нэгжийг судалгаанд ашиглуулсан.

МУ-ын Засгийн газрын 2000 оны 86 дугаар тогтоолын дагуу Архивын Ерөнхий газрын дэргэдэх мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвтэй хамтран архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шат сургалтад 5, мэргэшүүлэхийн сургалтад 17 албан хаагчийг хамруулж, сургалтыг цахимаар зохион байгуулж явуулсан.



журам”-ыг мөрдөн ашиглуулах зорилгоор шинж чанартай лавлагаа онд нийт 1254 иргэний лавлагаа, 913 иргэнд гаруй лавлагаа, хуулбар давхардсан тоогоор 6630



Сум, байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан болон төрийн албан хаагч нарт Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоол, 2011, 2021 оны Баримт бичгийн стандарт, “Байгууллагын үйл ажиллагааны нийтлэг журам”-аар “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн соёл” нэгдсэн сургалтыг зохион байгуулж, тус сургалтад нийт 68 төрийн байгууллагын 343 төрийн албан хаагчийг хамруулаад байна. Шинэчлэн батлагдсан эрх зүйн актуудыг сурталчлах, хэрэгжүүлэх үүднээс “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм, журмыг сурталчлан таниулах” 3 сарын аяныг 2021 оны 02 дугаар сарын 16-наас 05 дугаар сарын 16-ыг хүртэлх хугацаанд сум, байгууллагын ажиллалаа.

Архивын тасгийн үйл дэмжлэг үзүүлэх зорилгоор тус хангалт болон баримтын хадгаламжийн сангийн аюулгүй 7,860,000 төгрөгийн хөрөнгө



хэмжээнд зохион байгуулж

ажиллагааг сайжруулах, тасагт тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалт, байдалд зориулж нийт оруулалт хийсэн.



Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, гэрээний биелэлтийн тайлан мэдээ, дараа оны гэрээнд тусгах саналыг нэгтгэх талаар


Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх хүрээнд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллалаа. Үүнд:

Аймгийн Засаг даргаас газрын үйл ажиллагааг дэмжин “Явуулын 20.000.000 төгрөгөөр, баяр наадмын нийтийг хамарсан арга хэмжээний үеэр хамгаалалтад ашиглах зорилгоор хаалт 40 ширхэгийг 6,537.500, сумдын хэсгийн алба хаагчдын үйл ажиллагааг дэмжиж нийт 25.9 сая төгрөгийн автомашин, компьютер, принтер, бусад техник хэрэгслийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн.

Аймгийн ГХУСЗАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн байгууллагад ISO стандарт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн 10.000.000 (арван сая) төгрөгийг үе шаттайгаар шийдвэрлэхээр тусгаж, 2.500.000 (хоёр сая таван зуу) төгрөгийг олгосон.

Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойд зориулан түүхэн замналыг зурагт байдлаар багтаасан “Зурагт түүх”-ийн ном хэвлүүлэхэд нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.640.000, Цагдаагийн газрын бохир усны шугамыг шинэчлэх ажилд 15.0 сая төгрөгийг, Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Говь-Угтаал, Өндөршил, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Луус сумд цагдаагийн хэсгийн байрны засварт 21.209 сая, Баянжаргалан сум халаалтын урсгал зардалд 320.0 төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн.

Мөн хэсгийн алба хаагчдын эргүүл болон гэмт хэрэг шалгахад зориулан 9.278.280 төгрөгийг шатахууны зардалд, бусад зардалд 2.320.0 сая төгрөг зарцуулсан байна. Алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 14 сумын хэсгийн байрыг төвлөрсөн халаалтад шилжүүлж, 6 сумын халаалт, цахилгааны зардалд 5.5 сая



Цагдаагийн пост”-ыг болон олон хэв журмын хамгаалалтын цагдаагийн



төгрөгийг шийдвэрлэсэн. Цагдаагийн хэсгийн 4 алба хаагчийн гэр бүлийн хүнийг ажлын байраар хангасан.

Хүний эрхийн талаархи хууль тогтоомж, иргэд, байгууллагад сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь реферэнттэй хамтран иргэдэд хүний эрхийн зөрчлийн талаарх зөвлөгөө, мэдээллийг биечлэн болон Хуульчийн “Про Боно өдөр-2021” арга хэмжээний хүрээнд 05 дугаар сарын 01-ний өдөр цахим хэлбэрээр иргэд, олон нийтэд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан. Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь реферэнттэй хамтран иргэд, олон нийтэд хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэлд хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, ХЭҮК-д хандсан 3 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн.

Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч эрүүгийн 40 хэргийн төлбөрийн чадваргүй 49 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 275 иргэнд үзүүллээ. Аймаг, орон нутагт ажиллаж буй өмгөөлөгчид болон сумдад ажиллаж байгаа “Эрх зүйн хөтөч нарын дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэн сумдад нийт 310 ширхэгийг хүргүүлэв.

Хүний эрхийн аймаг дахь төлөөлөгч, Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгч нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчинг бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн ЗДТГ-аас бүрэн хариуцан үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /С.ЦЭНГЭЛМАА/

ТАЙЛАНГ ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Л.БАЯРСАЙХАН/

Дундговь аймаг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ 2021 ОНЫ АЖЛЫН МЭДЭЭ

Д/д	Ажлын чиглэл	Үзүүлэлт		Сум,	Хууль, эрх зүйн хэлтэс	Бүгд
1	Хууль тогтоомжийн системчлэл мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		“Төрийн мэдээлэл” сэтгүүл болон www.legalinfo.mn сайт ашигладаг	5099	5099
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо			157	157
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		-	3	3
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо		-	535	535
		Эрхзүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	198	86	284
			Байгууллага	143	152	295
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа, мэдээлэл өгсөн	Иргэд	165	345	510
			Байгууллага	188	225	413
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж		1298	420	1718
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж бүртгүүлсэн	-	3	3
			Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-	-	-
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг		189	9	198
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо		4459	779	5238
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа		219	14	233
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал		37төрөл/ 3300	2 төрөл/ 1050	39төрөл/ 4350
		ФМ, Радио, телевизийн нэвтрүүлэг		134	28	162
		Сонин хэвлэлээр сурталчилсан		21	3	24
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан		268	16	284

МЭДЭЭГ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /С.ЦЭНГЭЛМАА/

МЭДЭЭГ ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ /Л.БАЯРСАЙХАН/